

## **ЕВРОПЫН МОНГОЛЧУУДЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

### **1. Нийтлэг үндэслэл, зорилго**

- 1.1.** Энэхүү журам нь Европын Монголчуудын Волейболын холбооноос бусад байгууллага, клуб, хувь хүмүүстэй хамтран зохион байгуулж буй Волейболын тэмцээний үед оролцогч талуудын зайлшгүй даган мөрдөх үндсэн баримт бичиг болно.
- 1.2.** Европ дахь Монголчуудын дунд зохиогдож байгаа Волейболын тэмцээнийг Монголын Волейболын холбоо болон Олон улсын Волейболын спортын мөрдөж буй стандартад нийлүүлэн зохион байгуулах, хэвшүүлэх, мөрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

### **2. Тэмцээн зохион байгуулах эрх олгох**

- 2.1.** Европ дахь Монголчуудын Волейболын холбооны дүрэм болон хамтран тэмцээн зохион байгуулах энэхүү журамтай танилцан, дагаж мөрдөхийг зөвшөөрсөн Европын улсад амьдарч, үйл ажиллагаа явуулдаг спортын клуб, байгууллага, хувь хүнд тэмцээн зохион байгуулахаар гаргасан хүсэлтийн дагуу эрх олгоно.
- 2.2.** Хүсэлт гаргасан байгууллага, спорт клуб, хувь хүн:
  - Волейболын болон спортын бусад төрлөөр Европ дахь Монголчуудын дунд болон оршин суугаа улсдаа зохиогддог тэмцээн уралдааныг зохион байгуулж байсан ба оролцож байсан туршлагатай байх шаардлагатай.
  - Зохион байгуулах багт Олон улсын болон Монгол улсын Волейболын дээд зэрэглэлийн тэмцээнд дасгалжуулагч болон тамирчнаар оролцсон спортын зэрэгтэй байх зэрэг шаардлагыг хангасан, Монгол болон бусад улсад спортын мэргэжил эзэмшсэн гишүүд хамтран оролцож буй бол давуу тал болно.

### **2.3. Бүрдүүлэх материал:**

- Монгол улсаас тухайн улсад оршин суугаа ЭСЯ-наас хамтран зохион байгуулах эсхүл дэмжиж ажиллах тухай мэдээлэл
- Европ дахь Монголчуудын Волейболын холбоонд тухайн тэмцээнийг зохион байгуулах талаараа гаргасан албан хүсэлт
- Өөрийн болон хамтран зохион байгуулах байгууллага, хувь хүний талаар танилцуулга
- Тухайн тэмцээнийг хэрхэн зохион байгуулахаар төлөвлөж буй талаараа дэлгэрэнгүй мэдээлэл, хөтөлбөр

**2.4.** Ирүүлсэн хүсэлт материалууд батлагдсан шаардлагыг хангасан эсэхэд Удирдах зөвлөл дүгнэлт гарган гишүүдийн олонхын саналаар зохион байгуулах эрхийг олгоно.

## **3. Зохион байгуулах комисс**

- 4.1.** Тэмцээн зохион байгуулах эрх олгох шийдвэрийг үндэслэн хамтран ажиллах бүх талуудаас төлөөлөл бүхий тухайн тэмцээнийг зохион байгуулах комисс гаргана. Зохион байгуулах комисст оролцох гишүүд өөрсдөө саналаар оролцоно.
- 4.2.** Зохион байгуулах комисс тэмцээний ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн батална.
- 4.3.** Тэмцээнд шаардлагатай санхүүгийн асуудлыг зохион байгуулах комисс шийднэ.
- 4.4.** Зохион байгуулах комисс нь Европын Монголчуудын Волейболын холбооны мэргэжлийн болон бусад албадтай хамтран ажиллах үүргийг хүлээнэ.
- 4.5.** Зохион байгуулах комисс нь тэмцээн дууссаны дараа тайлан гаргаж, тэмцээнтэй холбоотой статистик мэдээлэл, зураг, материалыг Европын Монголчуудын Волейболын холбооны мэдээллийн санд ирүүлнэ.
- 4.6.** Зохион байгуулах комиссоос Тэмцээний ерөнхий шүүгчийг томилох ба Тэмцээний Ерөнхий шүүгч тухайн тоглолтын шүүгчдийг томилох ба шүүгчдийг хянаж ажиллана.

#### **4. Тэмцээн зохион байгуулах газар**

- 4.7.** Тэмцээний байр талбай, хэрэглэл материал олон улсын Волейболын холбооны стандартыг хангасан байна.
- 4.8.** Тоглолт явагдах талбай тус бүрт тоглолтын болон бие халаалтын бөмбөг бэлтгэсэн байх шаардлагатай.
- 4.9.** Тэмцээнийг 3 ба түүнээс дээш талбайд зэрэг тоглохоор зохион байгуулна.

#### **5. Техникийн зөвөлгөөн**

- 4.10.** Техникийн зөвөлгөөн болох хугацаа, байр танхимыг тэмцээний зааварт тодорхой тусгаж өгнө.
- 4.11.** Техникийн зөвөлгөөнийг бүх багаас дор хаяж нэг төлөөлөл оролцох зай талбай бүхий газар зохион байгуулна. Техникийн зөвөлгөөнд багын менежер, дасгалжуулагч, ахлагч нар эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулна.
- 4.12.** Техникийг зөвлөгөөнийг Тэмцээний Ерөнхий шүүгчийн удирдлага дор явуулж, тоглолтын хуваарь, кодексийг оролцож буй багын тоо болон талбайн тоог харгалзан бүх багуудын төлөөллийн хамтаар эцэслэн батлана.
- 4.13.** Техникийн зөвлөгөөний дараа тоглолтын хуваарыг тэмцээнд оролцогчид болон хөгжөөн дэмжигчдэд нээлттэй мэдээлнэ.

#### **6. Тэмцээн, тэмцээний насны ангилал**

- 6.1.** Дараах насны ангилалаар тэмцээн явагдаж болно.
- Насанд хүрэгчид: Эмэгтэй 16-аас дээш, Эрэгтэй 16-аас дээш
  - Ахмад: Эмэгтэй 36 нас ба түүнээс дээш, Эрэгтэй 40 нас ба түүнээс дээш
- 6.2.** Тухайн тэмцээнд баг, клубд хичээллэдэг 16 гаас доош өсвөр насны хүүхэд оролцох бол эцэг эхийн зөвшөөрлийг үндэслэн оруулцуулж болно.
- 6.3.** Нэг улсын баг, клуб бүх насны ангилалд хэдэн ч баг оролцуулж болно.
- 6.4.** Тамирчдын нэрс мэдүүлэгт давхардахгүй байх шаардлагатай.
- 6.5.** Нэг улсын болон баг, клубын ахмадын багт тоглож буй 1-2 тоглогчийг өөрийн баг, клубын насанд хүрэгчийн багт шилжин тоглохыг зөвшөөрнө. (Мэдүүлэгт нэр нь тусгагдсан байна).

## **7. Баг, багуудад тавигдах шаардлага**

- 7.1.** Тоглогч нь Европын холбооны улсад 6 сараас доошгүй хугацаанд амьдарсан байна.
- 7.2.** Багын бүрэлдэхүүн
- Тамирчин дээд тал нь 10 тамирчин
  - Дасгалжуулагч 1
  - Багын эзэн/менежер 1
- 7.3.** Тамирчид нь оршин суугаа улсаасаа өөр улсын багт тоглохыг зөвшөөрнө.
- 7.4.** Эцсийн мэдүүлэгт нэр нь бичигдсэн тухайн тэмцээний зааварт заасан, холбогдох бусад дүрэм журмын шаардлагыг хангасан тамирчидад зохион байгуулах хорооноос мандат олгоно.
- 7.5.** Тэмцээнд оролцож буй тамирчид дасгалжуулагч нар Европ дахь Монголчуудын Волейболын холбооны гишүүн болсон байх ба гишүүнчлэлийн эрхийн 5 еврог төлсөн байна.
- 7.6.** Тэмцээнд оролцох багууд стандартын тоглолтын хувцастай байна. Мэдүүлэгт бичигдсэн багын нэр, логотой байж болно.
- 7.7.** Тэмцээнд оролцох багийн эрхийн хураамжийг тухайн тэмцээний зааварт тусгаж өгнө. Тоглолтын хуваарь гарсанаас хойш тэмцээнд оролцохоос татгалзсан багийн эрхийн хураамж буцааж олгогдохгүй.

## **8. Гомдол гаргах / маргаан шийдвэрлэх**

- 7.8.** Тухайн тоглолт дууссанаас хойш 30 минутын хугацаанд багын менежер, дасгалжуулагч, ахлагч албан бичгээр зохион байгуулах комисс болон Ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй.
- 8.1.** Маргаан гаргах бүрт €50 евро барьцаа болгон тушаана. Маргаан нэхэмжлэх талд шийдэгдсэн тохиолдолд барьцааны мөнгийг эргүүлэн олгоно.
- 8.2.** Тоглолтын маргаантай асуудлыг Ерөнхий шүүгч, тоглолтын бус үед гарсан маргаантай асуудлыг Зохион байгуулах комисс хэлэлцэж 30 минутын дотор шийдвэрлэнэ.
- 8.3.** Багын ахлагч, дасгалжуулагчид тоглолтыг зөвшөөрч тэмцээний протоколд гарын үсэг зурсан тохиолдолд гомдолыг хүлээж авахгүй.

## **9. Эмнэлгийн үйлчилгээ**

**9.1.** Зохион байгуулах комисс тэмцээний үеэр ажиллах эмч, үзлэг хийх байрыг бэлдсэн байна. Эмчийн байрлалыг багуудын ахлагч, дасгалжуулагч нарт албан ёсоор мэдээлсэн байна.

**9.2.** Баг, тамирчид эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байхаа тус бүр хариуцна.

## **10. Хариуцлага ёс зүй**

**10.1.** Тэмцээнд оролцож байгаа бүх оролцогчид спортын шудрага өрсөлдөөнийг эрхэмлэн Олон улсын Волейболын холбооны холбогдох дүрэм, журмуудыг ёсчлон мөрдөнө. Тэмцээнд оролцох мандат авсан эрх бүхий этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд ямар нэгэн үүрэг гүйцэтгэх эрхийг шууд түтгэлзүүлнэ. Тамирчны ёс зүйг үл дээдлэх үйлдэл гаргаж, зохион байгуулалтад хүндрэл учруулах зөрчлийг зохион байгуулах комисс таслан зогсоох арга хэмжээ авна.

**10.2.** Зохион байгуулах комисс нь тэмцээнийг хэвийн явуулах зорилгоор эрх бүхий хамгаалалтын алба, цагдаагийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж болно.

**10.3.** Багийн удирдлагууд багийн тамирчдад Олон Улсын Волейболын холбооны дүрэм, Европийн Монголчуудын Волейболын холбооны тэмцээн зохион байгуулах энэхүү журмыг танилцуулсан байна.

## **11. Шагнал, урамшуулал**

**11.1.** Эхний гурван байр эзэлсэн багт медаль, мөнгөн шагнал, медалын батламж өгнө.

- Нэгдүгээр байр Алтан медаль
- Хоёрдугаар байр Мөнгөн медаль
- Гуравдугаар байр Хүрэл медаль

**11.2.** Мөнгөн шагналыг зохион байгуулах комисс хариуцаж гардуулна. Эхний гурван байр эзэлсэн багийн гишүүдэд медалын батламж дагалдах ба батламж дээр Монголын Волейболын холбоо, Европын Монголчуудын Волейболын холбооны бэлэгдэл лого, Ерөнхий ивээн тэтгэгчийн бэлэгдэл лого хэвлэгдсэн байна. Шилдэг тоглогчдын болон багт олгогдох цом бусад үнэ бүхий шагналыг зохион байгуулах комисс шийдвэрлэнэ.

**11.3.** Багуудын хураамжаас олсон орлогын 65%-аас багагүй хувь шагналын санд, үлдэгдэл орлого бусад үйл ажиллагаанд зарцуулна.